

ИНТЕРНЭТИЙН БӨӨНИЙ ҮЙЛЧЛЭГЧИЙН СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ ГЭРЭЭ

202.. оны сарын өдөр

№

Улаанбаатар хот

Нэг талаас **ИНТЕРНЭТИЙН БӨӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ** буюу “**ЖЕМНЭТ**” **ХХК**, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал С.Дэлгэрсайхан /цаашид **ҮЙЛЧЛЭГЧ** гэнэ/, нөгөө талаас **ИНТЕРНЭТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ** буюу “.....” **ХХК**, түүнийг төлөөлж /цаашид **ХЭРЭГЛЭГЧ** гэнэ/ нар / цаашид хамтад нь **ТАЛУУД** гэнэ/ харилцан тохиролцож, үйлчилгээ үзүүлэх зорилгоор дор дурдсан нөхцлөөр энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээний зорилго нь: Интернэтийн бөөний үйлчилгээ эрхлэгч нь өөрийн эзэмшлийн Мэдээлэл холбооны улс хоорондын сүлжээнд Интернэтийн үйлчилгээ эрхлэгчийн сүлжээг холбож, 24 цагийн турш тасралтгүй Интернэтийн холболтын үйлчилгээг үзүүлэх, Интернэт үйлчилгээ эрхлэгч нь үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасны дагуу төлөх, Талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.

Үйлчилгээний нэр: ИНТЕРНЭТИЙН БӨӨНИЙ УРСГАЛЫН СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ ҮЙЛЧИЛГЭЭ

Нэг. Ерөнхий зүйл


- 1.1 **ҮЙЛЧЛЭГЧ** нь ХХЗХ-ны “Мэдээлэл холбооны улс хоорондын сүлжээ байгуулах, түүнийг эзэмших, ашиглах” А ангиллын тусгай зөвшөөрлийн эзэмшигч байх ба “Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалтын нөхцөл шаардлага”-ыг хангасан өөрийн эзэмшлийн Мэдээлэл холбооны улс хоорондын сүлжээтэй байна.
- 1.2 **ХЭРЭГЛЭГЧ** нь ХХЗХ-ны “Харилцаа холбооны үйлчилгээг эрхлэх” Б ангиллын Интернэт үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийн эзэмшигч байна.
- 1.3 **ХЭРЭГЛЭГЧ**- ийн талаас өгөгдлийг оруулж, тухай бүрд нь баталгаажуулсан “Техникийн нөхцөл” болох 1-р хавсралт, “Захиалга, үнэ тариф”-ын хэсэг болох 2-р хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 1.4 **ТАЛУУД**- ын Төлөөлөл, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал, Үүсгэн байгуулагчид, Өмчлөгчид нь өөрчлөгдсөн эсэхээс үл хамаарч энэхүү гэрээ нь үйлчлэх хугацааны туршид хүчин төгөлдөр байна.

Хоёр. ҮЙЛЧЛЭГЧ- ийн эрх, үүрэг

- 2.1 **ХЭРЭГЛЭГЧ** нь “Интернэтийн бөөний үйлчилгээний сүлжээнд холбогдох” хүсэлтийг энэхүү гэрээний 3.1-т заасан мэдээлэл бүхий албан бичгээр Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос олгосон Б тусгай зөвшөөрлийн хуулбарын хамтаар **ҮЙЛЧЛЭГЧ**-д ирүүлэх ба **ҮЙЛЧЛЭГЧ** нь өөрийн сүлжээний техникийн боломжит нөхцөл дээр үндэслэн, сүлжээнд холбогдох техникийн нөхцлийн боломжийг тодорхойлж, ажлын 10 хоног дотор **ХЭРЭГЛЭГЧ**-д албан бичгээр мэдэгдэнэ.
- 2.2 **ҮЙЛЧЛЭГЧ** нь **ХЭРЭГЛЭГЧ**-ийг сүлжээнд холбох техникийн нөхцлийн боломжийг тодорхойлох зорилгоор энэхүү гэрээний 3.1-т зааснаас бусад нэмэлт мэдээллийг **ХЭРЭГЛЭГЧ**-ээс тодруулах эрхтэй ба энэ тухай **ХЭРЭГЛЭГЧ**-д гэрээний 2.1-т заасан хугацаанд албан бичгээр мэдэгдэнэ. **ХЭРЭГЛЭГЧ** нь тодруулгын мэдээллийг бүрэн ирүүлснээр **ҮЙЛЧЛЭГЧ** нь тус тодруулга бичгийг хүлээн авснаас ажлын 10 хоног дотор техникийн нөхцлийн боломжийг тодорхойлж, **ХЭРЭГЛЭГЧ**-д албан бичгээр мэдэгдэнэ.
- 2.3 **ҮЙЛЧЛЭГЧ** нь өөрийн сүлжээний техникийн боломжит нөхцөл дээр үндэслэн, сүлжээнд холбогдох гэрээний нөхцөл болон дараах техникийн нөхцөл шаардлагыг хангасан **ХЭРЭГЛЭГЧ**-тэй “Интернэтийн бөөний үйлчлэгчийн сүлжээнд холбогдох гэрээ”-г байгуулж, гэрээний дагуу үйлчилгээг үзүүлнэ.
 - 2.3.1. APNIC-аас IP хаягийн блок, AS дугаарыг авсан байх
 - 2.3.2. **ҮЙЛЧЛЭГЧ**-ийн сүлжээнд холбогдох зааглах цэг хүртэлх өөрийн талын сүлжээ,

дэд бүтцийн ашиглалт болон зааглах цэгт холболтыг хийх холболтын шугам, тоног төхөөрөмжийн техникийн бэлэн байдлыг шийдвэрлэсэн байх

- 2.3.3. **ҮЙЛЧЛЭГЧ**-ийн сүлжээнд холбогдох зааглах цэг дээр холболтын шугамыг оруулсан байх
- 2.3.4. Сүлжээнд холболт хийх сүлжээний төхөөрөмж нь Layer3 буюу түүнээс дээш түвшний төхөөрөмж байх
- 2.3.5. Сүлжээнд холбогдох техникийн нөхцлөөс хамаарч тодорхойлогдох нэмэлтээр хангах шаардлагатай техникийн нөхцлийг бүрдүүлэх
- 2.4 **ҮЙЛЧЛЭГЧ** нь хавсралт №2–д заасан үнэ тарифын дагуу үйлчилгээг тогтоосон стандартын дагуу шууд, чанартай шуурхай үзүүлнэ.
- 2.5 **ҮЙЛЧЛЭГЧ** нь үйлчилгээний бүтэц, журам, нөхцөл, үнэ тарифт өөрчлөлт хийх эрхтэй бөгөөд энэ тухайгаа **ХЭРЭГЛЭГЧ** -д хуанлийн 15 өдрийн өмнө албан бичгээр мэдэгдэнэ.
- 2.6 Төлөвлөгөөт болон техникийн үйлчилгээг жилд 4-өөс доошгүй удаа 3 цагаас ихгүй хугацаанд хийнэ. Ажлыг гүйцэтгэхдээ ажил гүйцэтгэх хугацааны талаар захиалагчид 48 цагийн өмнө мэдэгдэж **ХЭРЭГЛЭГЧ**-ийн саналыг авах ба хэрэв энэ хугацаа нь захиалагчид хүндрэлтэй бол илүү тохиромжтой хугацааг хамтран сонгоно. Энэ хугацааг **Үйлчилгээ** тасалдсанд тооцохгүй.
- 2.7 **ХЭРЭГЛЭГЧ** -ийн гаргасан хүсэлтийн дагуу шаардлагатай техникийн хэмжилт, туршилтыг хийж өгнө.
- 2.8 **ҮЙЛЧЛЭГЧ** нь техникийн болон холболтын шинэчлэлт хийх зэрэг зайлшгүй шалтгаанаар үйлчилгээгээр түр зогсоох шаардлага гарвал ажлын 2 хоногийн өмнө **ХЭРЭГЛЭГЧ**-д урьдчилан мэдэгдэж холболтыг **ТАЛУУД** тохиролцсоны үндсэн дээр холболтыг түр хугацаагаар таслах эрхтэй бөгөөд боломжтой бол нөөц замыг сонгох ба бололцооны хирээр тасалдалгүй, шуурхай чанартай үйлчилгээг үзүүлнэ.
- 2.9 Гадаад операторуудын сүлжээнд гарсан гэмтэл саатлын улмаас гарах хохирлыг **ҮЙЛЧЛЭГЧ** хариуцахгүй бөгөөд энэхүү гэмтэл нь ямар хугацаанд үргэлжлэх, хаана гэмтэл гарсан зэргийг **ХЭРЭГЛЭГЧ**-д мэдэгдэх үүргийг хүлээнэ.
- 2.10 Сүлжээнд гэнэтийн осол гарсан үед **ХЭРЭГЛЭГЧ**-д урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авахгүйгээр засварын ажлыг эхлэх эрхтэй бөгөөд энэ талаарх мэдээллийг **ХЭРЭГЛЭГЧ**-д ажлын явцын дунд өгнө.
- 2.11 **ХЭРЭГЛЭГЧ**-ийн буруутай үйл ажиллагаанаас гарсан гэмтэл, түүний буруу /сүлжээнд зохицохгүй тоног төхөөрөмж холбох г.м/ шийдвэрээс гарч болох сөрөг үр дагаврын хариуцлагыг **ҮЙЛЧЛЭГЧ** хүлээхгүй.
- 2.12 **ҮЙЛЧЛЭГЧ** нь шилэн кабелийн 1+1 хамгаалалт болон чиглэлийн хамгаалалтыг 2-оос доошгүй чиглэлд хийсэн байх ба аль нэг чиглэлд гэмтэл гарч нөгөө чиглэлдээ автоматаар шилжих, гэмтсэн шилэн кабелиас нөөц кабельд автоматаар шилжихдээ 15 минутын дотор шилжсэн тохиолдолд гэмтэл сааталд үл тооцно.
- 2.13 **ҮЙЛЧЛЭГЧ** ба **ХЭРЭГЛЭГЧ**-ийн зааглах цэг нь **ҮЙЛЧЛЭГЧ**-ийн кабелийн оруулалтын зогсоогуур ODF байна.



- 2.14 **ҮЙЛЧЛЭГЧ** ба **ХЭРЭГЛЭГЧ** нь сүлжээнд холбогдох зааглах цэгээс 2 тийш өөр өөрсдийн сүлжээнд гарсан гэмтэл болон сүлжээний ашиглалт, үйлчилгээг бүрэн хариуцна.
- 2.15 **ҮЙЛЧЛЭГЧ** нь дараах сүлжээний төвүүдийн зааглах цэг дээр **ХЭРЭГЛЭГЧ**-ийн сүлжээг өөрийн сүлжээнд холбох боломжтой.
 - 2.15.1. **УБ хотод:** УБ ЖемНэт POP1, УБ ЖемНэт POP2
 - 2.15.2. **Орон нутагт:** Сүхбаатар ТЗХ, Сүхбаатар МХС, Алтанбулаг МХС, Шаамар МХС, Дархан ТЗХ, Дархан МХС, Орхон МХС, Хөтөл МХС, Эрдэнэт МХС, Зүүнхараа

ТЗХ, Мандал ТЗХ, Багахангай ТЗХ, Чойр ТЗХ, Чойр МХС, Айраг ТЗХ, Сайншанд ТЗХ, Сайншанд МХС, Улаан-Уул ТЗХ, Замын-Үүд ТЗХ, Замын-Үүд МХС (Үгийн товчлол: POP – Сүлжээний төв, ТЗХ – Төмөр Замын Холбоо, МХС – Мэдээлэл холбооны сүлжээ)

- 2.16 **ҮЙЛЧЛЭГЧ**-ийн сүлжээнд холбогдох зааглах цэг дээрх холболтын техникийн ерөнхий мэдээлэл:
- 2.16.1. Төхөөрөмжийн интерфэйс: E1, FE, 1GE, STM-1, STM-4, STM-16, STM-64, 10GE LAN, 10GE WAN, 40GE, OTU2, 100GE, OTU4
 - 2.16.2. Холболтын шугам: Шилэн кабель, UTP кабель
 - 2.16.3. Холболтын төрөл: Copper, Optic SC, LC – SC, LC – LC, LC – FC
- 2.17 Гэрээний 2.16-д заасан зааглах цэг дээрх төхөөрөмжийн холболтын техникийн мэдээлэл нь тухайн сүлжээний төв дээр байрлах дамжуулах болон сүлжээний төхөөрөмжийн хүчин чадал, техникийн үзүүлэлт, багтаамж, түүний ашиглалт болон сүлжээний техникийн нөхцлийн боломжоос хамаарах тул сүлжээний төвүүд бүр дээр өөр өөр үзүүлэлттэй байна.
- 2.18 **ХЭРЭГЛЭГЧ** нь гэрээний 2.15.2-г заасан **ҮЙЛЧЛЭГЧ**-ийн орон нутаг дахь сүлжээнд холбох зааглах цэг дээр холболтыг хийх тохиолдолд **ХЭРЭГЛЭГЧ** нь УБ ЖемНэт POP1 сүлжээний төвөөс **ХЭРЭГЛЭГЧ**-ийн холболтыг хийх орон нутаг дахь сүлжээнд холбогдох зааглах цэг хүртэлх “Интернэт суваг түрээсийн үйлчилгээ”-г **ҮЙЛЧЛЭГЧ**-тэй “Тоон суваг түрээсийн гэрээ”-г байгуулж авах ба тус суваг түрээсийн үйлчилгээний нөхцөл, түүний төлбөрийг төлөх, **ТАЛУУД** хооронд үүсэх харилцааг “Тоон суваг түрээсийн гэрээ”-гээр зохицуулна.
- 2.19 **ҮЙЛЧЛЭГЧ**-ийн сүлжээний өргөтгөл, өөрчлөлт, сүлжээний ашиглалт, сүлжээний техникийн боломжит нөхцлөөс хамаарч энэхүү гэрээний 2.15, 2.16-д заасан **ҮЙЛЧЛЭГЧ**-ийн сүлжээний техникийн нөхцлийн мэдээлэлд өөрчлөлт орж болно.
- 2.20 **ҮЙЛЧЛЭГЧ** нь **ХЭРЭГЛЭГЧ**-д урьдчилан мэдэгдэлгүйгээр сүлжээг тасалсан тохиолдолд үйлчилгээ хүлээн аваагүй хугацааны төлбөрийг актыг үндэслэн **ХЭРЭГЛЭГЧ**-ийн ирэх сарын үйлчилгээний төлбөрөөс хасаж, тооцно.
- 2.21 **ҮЙЛЧЛЭГЧ** нь **ХЭРЭГЛЭГЧ**-ээс ирүүлсэн албан хүсэлтийн дагуу сүлжээнд холбогдох холболтын хурдыг нэмж, хавсралтаар гэрээг шинэчлэж, өөрчлөлтийг оруулна.
- 2.22 **ҮЙЛЧЛЭГЧ** нь **ХЭРЭГЛЭГЧ** –ийн хүсэлтээр техникийн зөвлөгөө, боловсон хүчний тусламж үзүүлж болно.
- 2.23 **ХЭРЭГЛЭГЧ** тал гэрээт хугацааны төлбөрийг 1 (нэг) сараас дээш хугацаагаар төлөөгүй тохиолдолд **ҮЙЛЧЛЭГЧ** тал **ХЭРЭГЛЭГЧ** талын үйлчилгээг урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр төлөгдөөгүй төлбөрийг төлөх хүртэлх хугацаанд хаах эрхтэй.

Гурав. **ХЭРЭГЛЭГЧ**-ийн эрх, үүрэг

- 3.1 **ХЭРЭГЛЭГЧ** нь “Интернэтийн бөөний үйлчилгээний сүлжээнд холбогдох” хүсэлтийг албан бичгээр ХХЗХ-ноос авсан Б тусгай зөвшөөрлийн хуулбарын хамтаар **ҮЙЛЧЛЭГЧ**-д ирүүлэх ба албан бичигт дараах мэдээллийг тусгасан байна.
- 3.1.1. **ҮЙЛЧЛЭГЧ**-ийн сүлжээнд холбогдох зааглах цэгийн байршил
 - 3.1.2. Сүлжээнд холболт хийх төхөөрөмжийн мэдээлэл
 - 3.1.3. Сүлжээнд холбогдох холболтын хурд буюу интернэт урсгалын хэмжээ
 - 3.1.4. Энэхүү гэрээний 2.3-г заасан сүлжээнд холбогдох техникийн нөхцөл шаардлагыг хангах бусад мэдээлэл
- 3.2 **ХЭРЭГЛЭГЧ** нь **ҮЙЛЧЛЭГЧ**-ийн сүлжээнд холбогдох зааглах цэг хүртэлх өөрийн сүлжээний дэд бүтэц болон сүлжээнд холбогдох холболтын шугам, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт, техникийн бэлэн байдал, ашиглалт үйлчилгээ, гэмтлийг бүрэн хариуцна.
- 3.3 **ХЭРЭГЛЭГЧ** нь энэхүү гэрээний 2.2-г заасны дагуу **ҮЙЛЧЛЭГЧ**-ээс ирүүлсэн тодруулгад хариу албан бичгийг ажлын 10 хоног дотор өгнө.
- 3.4 **ҮЙЛЧЛЭГЧ**-ээс сүлжээнд холбогдох боломжтой тухай техникийн нөхцлийг албан бичгээр хүлээн авснаас хойш 3 сарын дотор **ХЭРЭГЛЭГЧ** нь холболтыг хийж, үйлчилгээг эхлүүлээгүй тохиолдолд тухайн техникийн нөхцөл хүчингүй болсонд тооцно.
- 3.5 **ХЭРЭГЛЭГЧ** нь үйлчилгээний талаар санал, гомдлоо илэрхийлж, шийдвэрлүүлэх эрхтэй.
- 3.6 **ХЭРЭГЛЭГЧ** нь сүлжээнд холбогдох интернэт урсгалын хэмжээг нэмэх тохиолдолд

- албан хүсэлтээр саналаа хүргүүлэн интернэт урсгалын хэмжээг нэмүүлэх эрхтэй.
- 3.7 **ХЭРЭГЛЭГЧ** нь тухайн үйлчилгээтэй холбогдох, шаардлагатай тусгай зөвшөөрлийн эзэмшигч байх ба олон нийтэд үзүүлж буй үйлчилгээний талаар үүсэх асуудлыг Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны өмнө дангаар хариуцна.
 - 3.8 Үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрсөн хэв хэмжээнд, интернэтийн нийтлэг стандартын дагуу хуулийн хүрээнд ашиглана. Буруу хэрэглээнээс үүдэн гарах хариуцлагыг **ХЭРЭГЛЭГЧ** бүрэн хүлээнэ.
 - 3.9 **ХЭРЭГЛЭГЧ** нь **ҮЙЛЧЛЭГЧ**-ийн зөвшөөрөлгүйгээр сүлжээнд холбогдох үйлчилгээг гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.
 - 3.10 **ХЭРЭГЛЭГЧ** нь өөрийн компьютерийн дотоод сүлжээ, сервер компьютер болон сүлжээний нууцлал хамгааллын асуудлаа бие даан хариуцах бөгөөд энэ чиглэлээр **ҮЙЛЧЛЭГЧ**-тэй хамтран ажиллаж болно.
 - 3.11 **ХЭРЭГЛЭГЧ** нь өөрийн интернэт урсгалыг дамжуулах сүлжээний дамжуулалтын хурд урсгалын багтаамжийн үнэн зөв байдлыг хүссэн цагтаа шалгаж болох бөгөөд **ҮЙЛЧЛЭГЧ** нь шалгах боломжоор хангаж өгнө.
 - 3.12 **ҮЙЛЧЛЭГЧ**-ийн буруутай үйл ажиллагаанаас гарсан гэмтэл, түүний буруу (сүлжээнд зохицохгүй тоног төхөөрөмж холбох гэх мэт) шийдвэрээс гарч болох сөрөг үр дагаварын хариуцлагыг **ХЭРЭГЛЭГЧ** хүлээхгүй ба энэхүү асуудлыг шийдвэрлэхэд гарах үйлчилгээний зардлыг, гэмтлийн шалтгааныг тодруулсан актыг үндэслэн, **ҮЙЛЧЛЭГЧ** төлж барагдуулна.
 - 3.13 Үйлчилгээнд гарсан гэмтэл, саатлын талаар **ҮЙЛЧЛЭГЧ**-ийн 70160055-6001, 77100055 үйлчилгээний утсанд, techsupport@gemnet.mn и-мэйл хаягт даруй мэдэгдэнэ.
 - 3.14 Гэрээнд тусгагдсан **ХЭРЭГЛЭГЧ**-ийн и-мэйл хаягууд болон утасны дугааруудад өөрчлөлт орсон тохиолдолд **ХЭРЭГЛЭГЧ** өөрчлөлтийг тухай бүрт **ҮЙЛЧЛЭГЧ**-д албан бичгээр мэдэгдэнэ. Өөрчлөлтийг мэдэгдээгүйгээс үүсэх хариуцлагыг **ҮЙЛЧЛЭГЧ** хариуцахгүй.

Дөрөв. Төлбөр тооцооны талаар

- 4.1 **ҮЙЛЧЛЭГЧ** нь гэрээний хавсралт №2 т тусгагдсан үйлчилгээний үнэ, тарифыг аль болох бууруулах чиглэлийг баримталж ажиллах бөгөөд энэ талаар **ХЭРЭГЛЭГЧ** –тэй хамтран ажиллана. (Зах зээлээ өргөтгөх, багтаамжийг ихэсгэх г.м)
- 4.2 Үйлчилгээний үнэ тариф болон төлбөр төлөх аргачлалыг хавсралт №2-т тусгасны дагуу мөрдөнө.
- 4.3 Тухайн сард **ҮЙЛЧЛЭГЧ**-ийн төлөвлөгөөт болон техникийн үйлчилгээ нь 3 цагаас илүү хугацаагаар үргэлжлэн, Үйлчилгээ-г тасалдуулсан тохиолдолд тус илүү гарсан цагийн тасалдалд тасалдсан хугацааны тухай акт үйлдэх ба актыг үндэслэн ирэх сарын төлбөрөөс хасаж тооцно.
- 4.4 **ҮЙЛЧЛЭГЧ**-ийн сүлжээнд гарсан гэмтэл саатлын улмаас үйлчилгээ тасалдсан тохиолдолд үйлчилгээ хүлээн аваагүй цагийн төлбөрийг ирэх сарын төлбөрөөс хасаж тооцно.
- 4.5 **ХЭРЭГЛЭГЧ**-ийн авч байгаа үйлчилгээний үнэ тариф нь ямар нэгэн гишүүнчлэлээс үл хамаарах бөгөөд гагцхүү Монгол улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай.

Тав. Маргаан шийдвэрлэх

- 5.1 Энэ гэрээнд заагдаагүй аливаа асуудлыг Монгол Улсад дагаж мөрдөж буй хууль тогтоомжоор зохицуулна.
- 5.2 Гэрээтэй холбогдон үүсч болох аливаа маргаан, санал зөрөлдөөнийг **ТАЛУУД** хэлэлцээний журмаар шийдвэрлэх ба боломжгүй болсон тохиолдолд хуулийн байгууллагад хандана.
- 5.3 Гэрээг хэрэгжүүлэх явцад байгалийн гамшиг, дайн, хориг арга хэмжээ буюу түүнтэй адилтгах давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэлээс хамаарсан гэмтэл, саатлын хариуцлагыг **ТАЛУУД** хариуцахгүй.

Зургаа. Хугацаа

- 6.1 Гэрээний хүчинтэй хугацаа жил /..... жил/ байна.

- 6.2 Хэрэв аль нэг талаас гэрээг дуусгавар болгох санал гэрээний хүчинтэй хугацаа дуусахаас нэг сарын өмнө ирүүлээгүй тохиолдолд гэрээ нь цаашид тухай бүрт 1 (нэг) жилээр сунгагдаж явна.

Долоо. Гэрээг өөрчлөх буюу цуцлах

- 7.1 **ХЭРЭГЛЭГЧ** нь үйлчилгээг хүлээн авснаас хойш захиалгыг дуусгавар болгон цуцлах хүсэлт гаргах тохиолдолд гэрээг цуцлах тухай хүсэлтээ гэрээний хүчинтэй хугацаа дуусах хугацаанаас нэг сарын өмнө албан бичгээр ирүүлнэ.
- 7.2 Гэрээг дуусгавар болгох болон цуцлах үед **ТАЛУУД**-ын санхүү хариуцсан ажилчид тооцоо нийлж, өр төлбөргүйг харилцан баталгаажуулснаар гэрээг дуусгавар болсон болон цуцлагдсанд тооцно.
- 7.3 Гэрээний 7.4-т зааснаас бусад нөхцөлд **ХЭРЭГЛЭГЧ** нь гэрээний хүчинтэй хугацаа дуусахаас өмнө гэрээг цуцлах тохиолдолд тус гэрээний хүчинтэй хугацааны төлбөрийг бүрэн барагдуулж, **ТАЛУУД**-ын санхүү хариуцсан ажилчид тооцоо нийлж, өр төлбөргүйг харилцан баталгаажуулсны үндсэн дээр гэрээг цуцална.
- 7.4 **ТАЛУУД** дараах тохиолдолд гэрээг гэрээний хүчинтэй хугацаанаас өмнө цуцалж болно.
- 7.4.1. **ХЭРЭГЛЭГЧ**-ийн эзэмших “Интернэт үйлчилгээ эрхлэх эрх бүхий Б тусгай зөвшөөрөл” нь хуульд заасан үндэслэлээр хүчингүй болсон тохиолдолд **ҮЙЛЧЛЭГЧ** нь энэ тухай мэдээллийг хүлээн авсан өдрөөр тухайн **ХЭРЭГЛЭГЧ**-д үзүүлж байсан үйлчилгээг зогсоох ба **ТАЛУУД** хооронд тус өдрөөр үйлчилгээг хаасан тухай актыг харилцан баталгаажуулж, актыг үндэслэн төлбөр тооцоог зогсооно.
- 7.4.2. Гэрээний 7.4.1-т заасан үндэслэлээр үйлчилгээ хаагдсан **ХЭРЭГЛЭГЧ** нь үйлчилгээ хаагдсан өдрийг хүртэлх үйлчилгээний төлбөрийг **ҮЙЛЧЛЭГЧ**-д бүрэн төлөх үүрэгтэй ба **ТАЛУУД**-ын санхүү хариуцсан ажилчид тооцоо нийлж, өр төлбөргүйг харилцан баталгаажуулснаар гэрээг дуусгавар болсонд тооцно.
- 7.5 **ТАЛУУД** гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд санаачлагч **ТАЛ** ажлын 10 хоногийн өмнө бичгээр мэдэгдэж өөрчлөлт оруулна. Энэхүү өөрчлөлт нь **ТАЛУУД** гарын үсэг зурснаар баталгаажна.

Найм.Бусад

- 8.1 Энэхүү гэрээ нь **ТАЛУУД** харилцан гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.
- 8.2 **ТАЛУУД**-ын инженер техникийн ажилтнууд үйлчилгээ эхэлсэн болон дуусгавар болсон тухай актыг тухай бүр үйлдэж баримтжуулсан байна.
- 8.3 Гэрээг 2 хувь үйлдэж **ТАЛ** тус бүр нэг, нэг хувийг хадгалах ба гэрээний хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

“**ҮЙЛЧЛЭГЧ**”-ийг төлөөлөн:

“**ЗАХИАЛАГЧ**”-ийг төлөөлөн:

.....
“**ЖЕМНЭТ**” ХХК- ийн ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ С.ДЭЛГЭРСАЙХАН

.....

1. Техникийн нөхцөл

А. Үйлчилгээг ХЭРЭГЛЭГЧ

1. Ерөнхий мэдээлэл

Байгууллагын нэр:

Байгууллагын регистер:

Байршил:

Харилцах хүмүүс:

Удирдлага

Нэр: Утас: гар утас: и-мэйл:

Гэрээ, маркетинг

Нэр: Утас: гар утас: и-мэйл:

Инженер, техник

Нэр: Утас: гар утас: и-мэйл:

Санхүү/борлуулалт

Нэр: Утас: гар утас: и-мэйл:

2. Үйлчилгээний мэдээлэл

Захиалгын хугацаа: жил

3. Техникийн мэдээлэл

Сүлжээний Ай Пи (IP) блок хаяг	
AS №	
Холболтын хурд (Mbps)	
Интерфейс	
Анх холбогдсон сар,өдөр	

4. Захиалгын төрөл: Шинээр Өөрчилсөн:

Б. Үйлчилгээг ҮЙЛЧЛЭГЧ

1. Ерөнхий мэдээлэл

Байгууллагын нэр : ЖЕМНЭТ ХХК

Байгууллагын регистер: 5274478

Байршил: Монгол улс – 16052, Улаанбаатар хот, БГД 4-р хороо, Энхтайвны өргөн чөлөө-62,

Утас : 976-70160055, Факс : 976-21-250044, Шуудангийн хайрцаг – 39.

Харилцах хүмүүс:

Удирдлага: Гүйцэтгэх Захирал

Нэр: С.Дэлгэрсайхан гар утас: 93119009 и-мэйл: delgersaikhan@gemnet.mn

Инженер, техник: Техникийн албаны захирал

Нэр: Ц.Цогбаяр гар утас: 93110033 и-мэйл: tsogbayar.ts@gemnet.mn

Гэрээ, маркетинг: Менежер

Нэр: Ч.Оюунбат гар утас: 93110088 и-мэйл: oyunbat@gemnet.mn

Нэр: Ө.Мөнгөнзул гар утас: 93110330 и-мэйл: mungunzul@gemnet.mn

Санхүү: Албаны Захирал

Нэр: Ц. Бэгзсүрэн гар утас: 98101066 и-мэйл: begzsuren@gemnet.mn

Данс: Хас банк: 5001035412 /валютын/, 5001035406 /төгрөгийн/

ТАНИЛЦАН ЗӨВШӨӨРСӨН:

“ҮЙЛЧЛЭГЧ”-ийг төлөөлөн:

“ХЭРЭГЛЭГЧ”-ийг төлөөлөн:

.....
 “ЖЕМНЭТ” ХХК- ийн ГҮЙЦЭТГЭХ
 ЗАХИРАЛ С.ДЭЛГЭРСАЙХАН

.....

Үйлчилгээний гэрээ №ЖН-.....-ийн ХАВСРАЛТ-2

1. ИНТЕРНЭТИЙН БӨӨНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНДСЭН ЗАХИАЛГА, ҮНЭ ТАРИФ

№	Үйлчилгээний нэр	Холболтын хурд /Мб/с/	Нэгжийн үнэ 1 сард /төгрөг/	Нийт үнэ 1 сард /төгрөг/
1	Интернэтийн бөөний үйлчилгээний сүлжээнд холбож, интернэт холболтын үйлчилгээг үзүүлэх			
	Дүн			
	НӨАТ 10 %			
	НийтДүн			

Төлбөр тооцоо хийх аргачлал:

1. Төлбөрийг тооцооны сараар авах ба энэ хугацаа нь хуанлийн сартай тэнцүү байна.
2. Гадаад операторуудтай хийсэн гэрээний заалтын дагуу **ХЭРЭГЛЭГЧ** нь сарын үйлчилгээний төлбөрийг **ҮЙЛЧЛЭГЧ**-ийн нэхэмжлэхийн дагуу тухайн сарын 20-ны өдрийн дотор төлнө. Нэхэмжилсэн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд **ҮЙЛЧЛЭГЧ** нь ажлын 3 хоногийн дотор сануулга өгөх ба үүний дараа ажлын 5 хоногийн дотор төлбөр хийгдээгүй бол үйлчилгээг зогсоох эрхтэй.
3. **ХЭРЭГЛЭГЧ** нь хугацаандаа төлбөрөө төлөөгүй тохиолдолд хэтэрсэн хоног тутамд 0,3 хувийн алданги төлнө.
4. Тухайн сард гарсан гэмтлийн нийт хугацааг техникийн дүгнэлтийн үндсэн дээр акт үйлдэн тогтоож, үйлчилгээ тасалдсан хугацааны төлбөрийг ирэх сарын хураамжаас хасаж тооцно. Гэмтлийн актанд тухайн саатал гарсан шалтгаан, авсан арга хэмжээ, үргэлжилсэн нийт хугацаа болон түрээсийн төлбөрөөс хасч тооцох хугацаа зэргийг тодорхой зааж өгнө.
5. **ХЭРЭГЛЭГЧ** нь “Үнэ тариф”-д заасны дагуу нэхэмжилсэн төлбөрийг хавсралт №1-д заасан **ҮЙЛЧЛЭГЧ**-ийн валютын болон төгрөгийн дансанд шилжүүлнэ. Төлбөрийн даалгаврыг факсаар явуулах буюу и-мэйлээр илгээж болно.

ТАНИЛЦАН ЗӨВШӨӨРСӨН:

“**ҮЙЛЧЛЭГЧ**”-ийг төлөөлөн:

“**ХЭРЭГЛЭГЧ**”-ийг төлөөлөн:

.....
**“ЖЕМНЭТ” ХХК- ийн ГҮЙЦЭТГЭХ
 ЗАХИРАЛ С.ДЭЛГЭРСАЙХАН**

.....